



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/27-ШТА-ГА

**ТӨЛӨВЛӨСӨН ТОРГУУЛИЙН ОРЛОГО ДАВАН БИЕЛСЭН Ч ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТНУУДЫН 2023-2024 ОНД НОГДУУЛСАН 345.2 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН
ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж
Утас: 88953144 цахим хуудас: Davaadorbj@audit.gov.mn

Аудитор Ц.Дорж
Утас: 88114307 цахим хуудас: dorjts@audit.gov.mn

Аудитор Г.Энхзул
Утас: 99333147 цахим хуудас: enkhzulg@audit.gov.mn

Баянхонгор хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор Д.Даваадорж
Аудитор Ц.Дорж
Аудитор Г.Энхзүл

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....

БҮЛЭГ А. А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ УРЬДЧИЛАН ҮНДЭСЛЭЛТЭЙГЭЭР ТООЦООЛЖ, БОДИТ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

А.1. Хүү орлогыг дамжуулан зээлдүүлэх гэрээнд үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг төсвийн орлогын бүрэлдэхүүнд оруулан төсөв бүрдүүлэх зорилгоор төлөвлөж байна.

А.2 Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хүү, торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж, Сангийн яам жил бүр нэмж хянасан байна.

А.3. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ ?

Б.1. Төлөвлөсөн торгуулийн орлого даван биелсэн ч эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрэн хэрэгжээгүй байна.

Б.2. Хүү торгуулийн орлогыг хуваарилахдаа орлогын биелэлтээс үл хамааран батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байна.

БҮЛЭГ В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ ? 20

АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨӨС ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН ГАРСАН БАЙНА.

В.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зарцуулахдаа хуулийн дагуу зарцуулсан байна.

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг Шилэн данс, олон нийтэд мэдээллийн сувгаар хүргэж ил тод мэдээлсэн байна.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ,ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙГААГААС ОРЛОГО ТӨВЛӨРӨЛ ДУТУУ,ЗАРЦУУЛАЛТАД АЛДАА ГАРЧ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД БОДИТООР НЭГТГЭН ХЯНАХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.....

Г.1. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс шалтгаалан Монгол Улсын хэмжээнд нэг өдөрт хэдий хэмжээний торгууль ногдуулж, хэрэгжилт нь ямар түвшинд байгааг бодитой, нэгтгэсэн байдлаар хянах боломжгүй байна.

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий албан тушаалтнууд болон, улсын байцаагчид хяналтыг хэрэгжүүлсэн боловч орлого төвлөрүүлэлт дутуу, зарцуулалтад гарсан алдаа зөрчлөөс харахад хяналтын үр нөлөө сул байна.

ДҮГНЭЛТ: 29

ЗӨВЛӨМЖ: 30

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:.....

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

Товчилсон үгийн тайлбар	
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
УЕП	Улсын Ерөнхий прокурор
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ТЕГ	Татварын Ерөнхий газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нийгмийн даатгалын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	6
Хүснэгт 2	Хүү, торгуулийн орлогын өмнөх онуудын гүйцэтгэл	10
Хүснэгт 3	Хүүгийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/	13
Хүснэгт 4	Торгуулийн орлогын нэгтгэл /сая төгрөг/	15
Хүснэгт 5	Хүү торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/	17

Зураглалын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Зураглал №1 Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Зураглал 2	Зураглал №2 Сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Зураглал 3	Зураглал №3 Авто замын сан болон, ГХУС зардлын төсвийн хуваарь	18

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар, Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх. • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулав. Баянхонгор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн зардлын зарцуулалт, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн санд бүртгэлтэй байгаа хүү, торгуулийн орлогын данс тэдгээрт хуулийн дагуу орлого төвлөрүүлж буй аймгийн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын газар, Татварын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар бусад улсын байцаагч үүрэг гүйцэтгэж буй албан байгууллагууд хамрагдлаа.
Аудитын хязгаарлалт	Аудитад торгох эрх бүхий улсын байцаагчийн торгууль ногдуулж төсөвт төвлөрсөн орлогоос бусад төрлийн орлогыг хамруулаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн,

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Хүндрэл
бэрхшээл

нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Д.Даваадорж, Ц.Дорж, Г.Энхзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 5 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 6 дугаар сарын 27-ний өдрөөс эхлүүлж, тайланг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр газрын дарга, тэргүүлэх аудитораар баталгаажуулан Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.

Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан байна.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Төсвийн орлогын ангиллыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Төсвийн орлогын ангилал

(сая.төг)

Үзүүлэлт	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын орлого	20,190.1	23,644.6	32,158.4	38,202.0
Татварын бус орлого	47,652.6	43,781.6	64,914.0	60,008.0
Хүү, торгуулийн орлого	1,781.8	1,838.3	1,993.6	2,256.7

/Эх сурвалж: ТЕЗ тайлан 2023, 2024/

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 4.2-3.8 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Дээрх орлого 2023 онд 1,838.3 сая төгрөг байсан бол 2024 онд 2,256.7 сая төгрөг болж 22.8 хувиар өссөн байна.

Сумдын хэмжээнд торгуулийн орлогын бүрдүүлэлт

(сая.төг)

	Аймаг, Нийслэл	2023 он		2024 он		Нийт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баацагаан	10.0	9.9	14.0	9.1	24.0	18.9
2	Баянбулаг	3.0	5.9	3.0	6.5	6.0	12.4
3	Баянговь	5.0	3.6	5.0	3.7	10.0	7.3
4	Баянлиг	5.0	3.4	5.0	5.2	10.0	8.5
5	Баян-овоо	20.0	28.3	20.0	23.3	40.0	51.6
6	Баян-өндөр	8.0	21.8	6.0	6.1	14.0	27.9

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

7	Баянхонгор	138.8	217.8	250.0	200.2	388.8	418.0
8	Баянцагаан	6.0	5.7	5.0	6.2	11.0	12.0
9	Богд	5.0	5.6	4.0	8.4	9.0	14.0
10	Бөмбөгөр	40.0	89.8	60.0	113.7	100.0	203.5
11	Бууцагаан	30.0	75.6	45.0	138.3	75.0	213.8
12	Галуут	20.0	16.8	28.0	27.9	48.0	44.7
13	Гурванбулаг	6.0	10.7	7.5	17.9	13.5	28.6
14	Жаргалант	10.0	15.8	10.0	7.2	20.0	23.0
15	Жинст	4.0	3.0	3.0	4.3	7.0	7.2
16	Заг	7.0	6.3	5.0	3.1	12.0	9.4
17	Өлзийт	70.0	163.0	170.0	229.1	240.0	392.1
18	Хүрээмарал	13.0	17.9	4.0	1.8	17.0	19.7
19	Шинэжинст	8.0	21.2	15.0	13.7	23.0	34.9
20	Эрдэнэцогт	3.0	11.6	4.0	8.1	7.0	19.6
НИЙТ		411.8	411.8	733.7	663.5	833.8	1,075.3

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ СТСХ/

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс ирүүлсэн мэдээллээр аймгийн хэмжээнд 2023-2024 онуудад 1,567.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг бүрдүүлсэн байна.

Харин Хоршоо хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн зээлийн хүүгийн орлого нь тухайн санд төвлөрдөг байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая.төг)

Д/д	Байгууллагын нэр	2023			2024		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү/дутуу	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү/дутуу
1	Галуут сум ХХС		7.0	7.0	7.7	8.4	0.7
2	Баян-Овоо сум ХХС		4.4	4.4		3.9	3.9
3	Эрдэнэцогт сум ХХС		0.2	0.2		4.0	4.0
4	Бууцагаан сум ХХС		2.2	2.2		6.7	6.7
5	Жинст сум ХХС		4.1	4.1		2.8	2.8
6	Баянлиг сум ХХС		2.8	2.8		2.8	2.8
7	Баянговь сум ХХС		4.8	4.8		3.1	3.1
8	Гурванбулаг сум ХХС		-	-		-	-
9	Богд сум ХХС		3.8	3.8		4.9	4.9
10	Жаргалант сум ХХС		1.3	1.3	3.1	5.0	1.9
11	Заг сум ХХС		4.6	4.6		1.5	1.5
12	Баацагаан сум ХХС	6.0	6.2	0.2	4.2	4.4	0.2
13	Бөмбөгөр сум ХХС		2.9	2.9		4.4	4.4
14	Өлзийт сум ХХС		7.9	7.9		3.8	3.8
15	Хүрээмарал сум ХХС		3.2	3.2		5.8	5.8
16	Баянбулаг сум ХХС	3.8	5.9	2.1		4.4	4.4
17	Баян-Өндөр ХХС		2.7	2.7		3.2	3.2
18	Баянцагаан сум ХХС		5.1	5.1		2.8	2.8
19	Шинэжинст сум ХХС	3.8	5.8	1.9	5.8	12.0	6.3
20	Баянхонгор сум ХХС	13.5	13.3	(0.2)	39.7	12.4	(27.3)
Нийт		27.1	88.3	61.2	60.5	96.6	36.2

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогыг 2023 онд 4 сум 27.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 88.3 сая төгрөг орсон байна. Харин 2024 онд 5 сум 60.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 96.6 сая төгрөг орсон байна

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ А. А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ УРЬДЧИЛАН ҮНДЭСЛЭЛТЭЙГЭЭР ТООЦООЛЖ, БОДИТ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

*А.1. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн үү?***А.1. Хүү орлогыг дамжуулан зээлдүүлэх гэрээнд үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг төсвийн орлогын бүрэлдэхүүнд оруулан төсөв бүрдүүлэх зорилгоор төлөвлөж байна.***А.1.1. Хүүгийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөсөн үү?*

Баянхонгор аймгийн орон нутгийн орлогын төсвийн төсөлд хүүгийн орлогыг өмнөх жилийн гүйцэтгэд үндэслэн төлөвлөснийг Сангийн яам нэмэгдүүлэн хянасан бөгөөд суурь орлогыг бууруулахгүй байх зарчмыг баримтлан 2023 онд 750.7 сая, 2024 онд 47.6 сая төгрөгөөр төлөвлөн, аймгийн ИТХ-аар баталсан байна.

Сангийн яамнаас дэд бүтцийн чиглэлээр “Чандмань Баянхонгор” ХК, “Баянхонгор эрчим хүч” ХХК-д өмнөх жилүүдэд олгосон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүгийн орлогыг 2023-2024 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлж эргэн төлүүлэхээр төлөвлөсөн байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, ажилгүйдэл гэсэн 4 сангийн данс арилжааны банканд байршдаг бөгөөд аудит хамрах хугацаанд харилцах дансны хүүгийн орлогыг төлөвлөж НДЕГ-ын даргын 2022 оны 06, 2024 оны А/240 дугаар тушаалаар баталгаажуулсан байна.

Хүснэгт №1. НД-ын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 оны Төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	2024 оны Төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл
А	1	2	3	4
2. Харилцахын хүүгийн орлого	24.9	46.5	40.3	43.7

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10.2¹, 11.1.4², тус хуулийн 12 дугаар зүйл³ заалтуудтай нийцүүлэн бодит хэрэгцээ шаардлагын дагуу төлөвлөсөн байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг тухайн жилд зээлдэгч нарын зээлийн гэрээний дагуу төлөх үндсэн зээл, хүүгийн хэмжээгээр, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөж, сумдын ИТХ-аар баталсан байна.

Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн “Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1.3, 2.1.4 -т заасантай нийцэж байна.

Тухайлбал: Шинэжинст, Баацагаан, Баянхонгор, Галуут, Жаргалант сум зээлийн хүүгийн орлогыг батлахдаа тусад нь төлөвлөсөн бол бусад сумд тухайн жилд төлөгдөх зээл, хүүгийн эргэн төлөлтийн нийт дүнгээр баталсан байна.

¹ Нийгмийн даатгалын сан тус бүр банканд данстай байна² сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого³ Нийгмийн даатгалын сангийн зарлага

Баянхонгор аймагт жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор “Баянхонгор-Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ОНӨААТҮГ нь хөнгөлөлттэй зээл олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус корпорац нь 2023 онд 19.1 сая төгрөг, 2024 онд 10.5 сая төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж, зээлийн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн боловч зээлийн хүүгийн орлогыг зорилтот түвшинд төлөвлөхгүй байна.

А.1.2. Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлага байна уу?

Баянхонгор аймгийн орон нутгийн төсөвт Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3⁴ т заасан төсвийн орлогын нэг хэсэг болох торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төлөвлөгөөний дагуу аймаг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолуудаар тодотгон 2023 онд 1,781.8 сая, 2024 онд 1,946.8 сая төгрөгөөр төлөвлөж тус тус баталжээ.

Торгуулийн орлогыг төлөвлөснөөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁵, “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4⁶-д заасны дагуу орлогын тодорхой хувийг зориулалтын дагуу төлөвлөж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

А.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн, төлөвлөсөн үү?

А.2 Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хүү, торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж, Сангийн яам жил бүр нэмж хянасан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс хүү, торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн төсвийн төслийг төлөвлөн Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд уг төсвийг Сангийн яам хянан, нэмж баталгаажуулсан байна.

А.2.1. Торгуулийн орлогын биелэлт нь өмнөх жилүүдэд илүү, дутуу биелсэн байна уу?

Баянхонгор аймгийн хэмжээнд нийт торгуулийн орлогын төлөвлөгөө сүүлийн 3 жилийн хугацаанд 105-112 хувийн гүйцэтгэлтэй давж биелсэн байна.

Зураглал №1 Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл




⁴ Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

⁵ торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

⁶ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

Баянхонгор сум болон улсын чанартай зам дагуу байршдаг Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан сумын торгуулийн орлогын гүйцэтгэл бусад сумдаас харьцангуй өндөр байна.

Зураглал №2 Сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Аймгийн хэмжээнд нийт торгуулийн орлого төлөвлөгөөнөөс давсан бол сумдын орлогын гүйцэтгэл харилцан адилгүй байна. Энэ нь торгуулийн орлогыг урьдчилан тооцох бололцоогүй, тохиолдлын шинж чанартай байгаагаас шалтгаалсан байна.

А.2.2. Орлогыг төлөвлөхдөө тоо хэмжээ болон суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна уу?

Улсын байцаагчид торгуулийн орлогын урьдчилсан тоо суурь судалгаа гаргах боломжгүй учраас Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж, Сангийн яам жил бүр нэмж хянасан байна.

Баянхонгор аймгийн Санхүү Төрийн Сангийн хэлтэс сүүлийн 5 жилийн орлогын суурь судалгаа болон гүйцэтгэлд тулгуурлан 2021-2024 онуудад аймгийн нийт торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс өсгөж гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

Үзүүлэлт	Нэгтгэл			
	2021	2022	2023	2024
	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө
5. Хүү торгууль	1,277.3	1,648.4	1,781.8	2,033.5

Орлогын төлөвлөгөөг төлөвлөхдөө эдийн засгийн нөхцөл байдлаас хамааруулан Сангийн яамнаас баталж ирүүлсэн орлогын төлөвлөгөөг тухайн жилийн аймгийн төсөвт оруулан баталж иржээ.

Баянхонгор аймгийн сумд хүү, торгуулийн орлогын төлөвлөлт харилцан адилгүй байна.

Тухайлбал: Богд, Баян-Өндөр, Хүрээмарал сумд өмнөх жилүүдэд торгуулийн орлогыг 116 хувиар биелүүлсэн байхад 2024 оны торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн гүйцэтгэлээс бууруулан, Баацагаан, Галуут сумд өмнөх жилийн торгуулийн орлогын төлөвлөгөө биелээгүй байхад 2024 онд нэмэгдүүлэн, Баянбулаг, Заг сумд сүүлийн 3 жилийн торгуулийн орлогын төлөвлөгөөг ижил дүнгээр баталсан байна.

А.2.3. Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөсөн үү?

Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарахгүйгээр зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн орлоготой уялдуулан төлөвлөж байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас олгогдож буй хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг төлөвлөхдөө тухайн сангийн өмнөх жилд олгосон зээлийн хүүгийн орлого, тайлант онд олгогдох зээлийн хүүгийн орлого зэргийг үндэслэн тооцож байна.

А.2.4. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолсон уу?

Торгуулийн орлогоос дараах хуульд заасан арга хэмжээнд зарцуулахаар тооцоолсон байна. Үүнд Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁷-т заасны дагуу, Аймгийн авто замын сангийн үйл ажиллагаанд “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4⁸-д заасны дагуу зарцуулахаар төлөвлөсөн байна.

Харин сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээлийн хүүгийн орлогыг тухайн сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас дараа онд олгох зээлийн эх үүсвэрийн нэг хэсэг болгон төлөвлөж байна.

А.2.5. Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэсэн үү?

Баянхонгор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн орлогын төлөвлөлтийг хийхдээ өмнөх жилүүдийн төсвийн орлогын гүйцэтгэлийг харьцуулан судалж, суурь мэдээлэл болгон ашигладаг байна.

Төсвийн төсөлд хүү, торгуулийн орлогыг тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл өмнөх жилийн гүйцэтгэл зэргийг үндэслэн тооцоолж, бэлтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Хүү торгуулийн орлогын гүйцэтгэлд торгуулийн орлого бүрдүүлдэг эрх бүхий байгууллагуудын тогтоосон болон хэрэгжсэн орлогын дүнд нарийвчлан шинжилгээ хийгээгүй байна.

⁷ торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

⁸ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

Тухайлбал: Судалгаагаар 2023, 2024 онуудад нийт 63505 иргэн, хуулийн этгээдэд 2,801,739.4 сая төгрөгийн торгууль ногдуулснаас орон нутгийн төсөвт 2,103,808.8 сая төгрөг, улсын төсөвт 230,440.1 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрсөн байна.

Огноо	Ногдуулсан торгуулийн тоо	Ногдуулсан торгууль	Хэрэгжсэн	Зөрүү
2023 он	33,981	1,595,973.3	1,423,455.2	(172,518.1)
2024 он	29524	1,205,766.1	910,793.7	(294,972.4)
Нийт	63,505	2,801,739.40	2,334,248.90	(467,490.50)

Энэ нь зөвхөн орон нутгийн орлогын дансанд орсон мөнгөн дүнг үндэслэн төлөвлөлт хийж байгаатай холбоотой байна.

Иймд Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлийг эрх бүхий төрийн байгууллагуудаас тогтоосон торгууль болон хэрэгжсэн орлогын гүйцэтгэлд үндэслэн дүн шинжилгээ хийж төлөвлөж байх зөвлөмжийг Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т өгөв.

А.2.6. Орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолсон уу?

Баянхонгор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь 2023, 2024 онуудад торгуулийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа торгуулийн орлогыг эрх бүхий байгууллагуудаас дараах аймгийн ерөнхий орлогын дансанд оруулахаар тооцоолж төлөвлөсөн ба гүйцэтгэл нь дараах байдалтай байна.

Хүснэгт №2. Аймгийн торгуулийн орлогын гүйцэтгэл

	2023 он төлөвлөгөө	2023 он гүйцэтгэл	Хувь	2024 он төлөвлөгөө	2024 он гүйцэтгэл	Хувь
Төрийн аудит газар	136.0	158.2	116.4	136.0	174.3	128.1
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	312.5	219.2	70.1	312.5	350.6	112.2
Татварын хэлтэс	60.0	51.4	85.7	60.0	193.6	322.6
Санхүүгийн хяналт аудитын газар	230.0	149.1	64.8	230.0	184.5	80.2
Цагдаагийн газар	631.5	549.6	87.0	631.5	498.7	79.0
Нийт	1,370.0	1,127.5	82.3	1,370.0	1,401.6	102.3

Хэдийгээр нийт гүйцэтгэл 2024 онд 100 хувиас давсан ч, торгуулийн орлогын гол эх үүсвэр бүрдүүлдэг Цагдаагийн газар, Санхүүгийн хяналт аудитын газарт зэрэг байгууллагуудын хувьд хоёр жил дараалан төлөвлөсөн хэмжээнээс доогуур гүйцэтгэлтэй байна.

Торгуулийн орлогыг урьдчилан төлөвлөх нь Төсвийн орлого бүрдүүлэлт тасалдах, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авто замын тухай хуулийн дагуу зорилтот санд хуваарилах орлогын эх үүсвэр хангалтгүй байх эрсдэл үүсэхээр байна.

Өмнөх жилийн гүйцэтгэлээр дараа жилийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн тогтолцоо нь дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байна.

Иймд өмнөх жилийн гүйцэтгэлээр дараа жилийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн тогтолцоо бий болгохыг эрх бүхий байгууллагад зөвлөмжөөр хүргүүлэх саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлав.

А.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн байна уу?

А.3. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

А.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байна уу?

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг зохицуулж буй эрх зүйн орчин нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль зэрэг үндсэн хуулиудаас гадна холбогдох салбарын бодлого, журам, аргачлалуудыг хамаарч байгаа бөгөөд эдгээрийн уялдаа, хэрэгжилт нь орлого бүрдүүлэлтэд шууд нөлөө үзүүлж байна.

Баянхонгор аймагт жижиг дунд үйлдвэрлэл, хоршоодын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 16 тогтоол “Баянхонгор аймгийг хөгжүүлэх нэгдсэн бодлого”, 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 9/16 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэх журам”-ыг хэрэгжүүлж байна.

Эдгээр хуулиуд нь торгуулийн орлогод ямар байгууллагаас, ямар зөрчлийн үндсэн дээр хэрхэн бүрдэж, хуваарилагдахыг тодорхой заасан нь бодит хэрэгцээ шаардлагыг хангаж харилцан уялдаатай байна.

Харин Цагдаагийн газраас бэлэн бусаар оногдуулсан торгуулийг зарим иргэн санаатайгаар төлөхгүй байгаа нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. УЕП, ХЗДХС-ын хамтарсан 2024 оны А/42, А/71 дугаар тушаалаар баталсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох, хугацаа, аргачлал” журмын 2.5-д зааснаар, торгууль төлөөгүй этгээдийг оршин суугаа газар нь эсхүл харьяа шүүхэд танилцуулж хүргүүлэх үүргийг шийтгэл оногдуулсан алба хаагч хүлээдэг нь хүндрэл учруулж байна.

Иймд иргэд төрийн цахим үйлчилгээ авах үедээ өөрийн нэр дээр оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг мэдэгдлээр авах, мөн торгуулийн төлбөрөө төлөөгүй тохиолдолд зарим төрийн цахим үйлчилгээ авах эрхийг түр хугацаагаар хязгаарлах, төлбөрийг барагдуулсны дараа үйлчилгээг сэргээх зохицуулалтыг журамд тусгах талаарх саналыг аудитын багийн зүгээс нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлав.

А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан уу?

Хүү тооцох аргачлал, хувь хэмжээг холбогдох журмууд болон гэрээний нөхцөлөөр тодорхойлж байгаа боловч энэ чиглэлд нэгдсэн хууль эрх зүйн зохицуулалт, тусгайлсан хууль бүрдээгүй байна. Тухайлбал, Хоршоо хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлөлттэй зээлийн хүүг “Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.5.1-д зааснаар жилийн 3

хувиар, “Баянхонгор-Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК нь зээлийн хүүг “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ын 1.2-т заасан жилийн 3 хувиар тус тус тогтоон, журмыг баримтлан хэрэгжүүлж байна. Харин Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны чөлөөт үлдэгдэлд банкны ерөнхий нөхцөл болон гэрээний үндсэн дээр хүү тооцон орлого олж байна.

А.3.3. Тодорхойгүй маргаантай заалтууд орлого бүрдүүлэлтэд сэргөөр нөлөөлж байна уу?

Эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой тодорхойгүй, давхардсан, эсхүл маргаан үүсгэхээр заалт илрээгүй болно.

А.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байна уу?

Аудитаар нийт 31 торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнаас 2024 онд нийт 28,822 торгуулийг ногдуулсан байгааг түүвэрлэн судлахад, торгуулийн хэмжээ болон торгосон үндэслэл нь ихэнх тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцэж, зөрчлийн шинжид тохирсон байсан.

Харин Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх “жолооны үнэмлэхийн хугацаа дууссан” шалтгаанаар өндөр торгууль ногдуулж буй заалт нь иргэдийн бухимдал, гомдлыг дагуулж байна.

А.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж чадаж байна уу?

Баянхонгор аймгийн хэмжээнд торгуулийн орлого нь Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад салбарын хууль, дүрэм, журмын хүрээнд бүрдэж байгаа хэдий ч зарим тохиолдолд хууль хэрэглэх үйл явцад алдаа байна.

Тухайлбал, Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагч нь 2024 онд хүчингүй болсон хуулийн заалтыг ашиглан торгууль ногдуулсан тохиолдол бүртгэгдсэн байна. Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн 14.5.15 дугаар заалтыг үндэслэн, шатах тослох материалыг төвлөрсөн хот, суурин газрын замаар өдрийн цагаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээвэрлэсэн гэх үндэслэлээр иргэнд 300,000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Гэвч уг заалт тухайн үед хүчин төгөлдөр бус байсан тул Цагдаагийн ерөнхий газрын Стратеги, бодлого, инновац хөгжлийн албаны Мэдээлэл технологийн хэлтсээс мэдээллийн нэгдсэн сангаас торгуулийн шийтгэлийн хуудсыг хасуулж, ногдуулсан торгуулийг цуцлуулсан байна. Үүнтэй холбогдуулан хууль буруу хэрэглэсэн алба хаагчид хариуцлага тооцож, тухайн торгуулийг төлүүлсэн нь ЦЕГ-аас 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 336/4339 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбар болон торгууль төлсөн баримтаар нотлогдож байна.

Энэ нь хууль хэрэглэх явцад алдаа гарч, улмаар тухайн иргэний хууль ёсны эрх зөрчигдөх эрсдэл байгааг харуулж байгаа бөгөөд цаашид эрх бүхий албан тушаалтнуудын хууль хэрэглээний мэдлэг, мэдээллийг тогтмол сэргээн дээшлүүлэх, хүчингүй болсон хуулийн заалтыг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна уу?

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэл нь ихэвчлэн Зөрчлийн тухай хууль болон холбогдох салбарын хууль тогтоомж дээр суурилдаг хэдий ч зарим заалт нь бодит нөхцөл байдал, иргэдийн эрх, эдийн засгийн чадавхтай нийцэхгүйгээр хэрэгжиж байгаа нь шинэчлэл хийх шаардлагыг бий болгож байна.

Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байдаг.

Гэвч энэхүү заалтаар жолоодох эрхээ хасуулсан хүн болон жолооны үнэмлэхийн хугацаа автоматаар дууссан этгээдийг адилхан хэмжээний торгууль оногдуулж байгаа нь зөрчлийн шинж чанар, нийгмийн хор уршгийн түвшин зэргийг харгалзахгүй, ялгаатай зөрчлийг ижил торгуульд хамруулж буй хууль зүйн зөрүүтэй зохицуулалт юм.

Иймд Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх “жолооны үнэмлэхийн хугацаа дууссан” энэхүү заалтыг орчин үеийн техник технологитой уялдуулан цахим бүртгэлээр зөрчил гаргаагүй жолоочид автоматаар үнэ төлбөргүй сунгах эрх зүйн зохицуулалт оруулах зөвлөмжийг эрх бүхий байгууллагад хүргэх саналыг аудитын багийн зүгээс нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлав.

А.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөж байна уу?

Баянхонгор аймгийн хувьд 2023, 2024 онуудад нийт 2,908.9 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 380.7 сая төгрөгийн орлого нь одоог хүртэл бүрэн хэрэгжээгүй бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу албадан гүйцэтгэсэн тохиолдол илрээгүй байна.

БҮЛЭГ Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ ?

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН НОГДУУЛСАН 380.8 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГО ОДООГООР БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Ногдуулсан хүү, торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт хангагдсан уу?

Б.1. Төлөвлөсөн торгуулийн орлого даван биелсэн ч эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрэн хэрэгжээгүй байна.

Б.1.1. Хууль, журмын дагуу тогтоосон хүү, торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2023 оны эхэнд 1,146.1 сая төгрөг байсан ба тайлан онд зээл хүүгийн эргэн төлөлтөөс 1,298.9 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,169.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 930.8 сая төгрөгийн зарлага гаргаж оны эцэст 1384.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Харин 2024 онд зээлийн эргэн төлөлтөөр 1,575.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 931.9 сая төгрөгийг төвлөрүүлж 467.8 сая төгрөгийн зарцуулж оны эцэст 1,848.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 3. Хүүгийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	2023			2024		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү/дууту	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү/дууту

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

1	Аймгийн Нийгмийн даатгалын газар	24.97	46.52	21.55	40.37	43.77	3.40
2	Үйлдвэржилт хөгжлийн корпорац		10.46	10.46		19.07	19.07
3	Галуут сум ХХС		6.98	6.98	7.70	8.43	0.73
4	Баян-Овоо сум ХХС		4.36	4.36		3.92	3.92
5	Эрдэнэцогт сум ХХС		0.20	0.20		4.05	4.05
6	Бууцагаан сум ХХС		2.20	2.20		6.74	6.74
7	Жинст сум ХХС		4.14	4.14		2.76	2.76
8	Баянлиг сум ХХС		2.85	2.85		2.85	2.85
9	Баянговь сум ХХС		4.78	4.78		3.15	3.15
10	Гурванбулаг сум ХХС		-	-		-	-
11	Богд сум ХХС		3.83	3.83		4.87	4.87
12	Жаргалант сум ХХС		1.33	1.33	3.11	5.03	1.92
13	Заг сум ХХС		4.62	4.62		1.48	1.48
14	Баацагаан сум ХХС	6.00	6.24	0.24	4.16	4.39	0.23
15	Бөмбөгөр сум ХХС		2.87	2.87		4.43	4.43
16	Өлзийт сум ХХС		7.90	7.90		3.81	3.81
17	Хүрээмарал сум ХХС		3.16	3.16		5.82	5.82
18	Баянбулаг сум ХХС	3.78	5.92	2.14		4.43	4.43
19	Баян-Өндөр ХХС		2.70	2.70		3.21	3.21
20	Баянцагаан сум ХХС		5.12	5.12		2.79	2.79
21	Шинэжинст сум ХХС	3.83	5.76	1.93	5.76	12.02	6.26
22	Баянхонгор сум ХХС	13.50	13.31	(0.19)	39.73	12.44	(27.29)
Нийт		52.08	145.25	93.17	100.83	159.46	58.53

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хүү, торгуулийн судалгаа

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, хүүгийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрөөгүй, зээлдэгч нар гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүйгээс зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн зөрчил буурахгүй байна. Тухайлбал:

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 307.5 сая төгрөгийн зөрчил илэрч 3.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 273.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 213.9 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна

Харин 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 416.9 сая төгрөгийн 14 зөрчил илэрч 238.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 178.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн "Үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК 2023 онд нийт 10.5 сая төгрөг, 2024 онд 19.1 сая төгрөгийн зээлийн хүүгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын байгууллагын хувьд тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого төвлөрч байгаа бөгөөд энэ нь санхүүгийн нэмэлт эх үүсвэр болж байна.

2. Торгуулийн орлого

Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 1,781.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг төлөвлөж 1,838.3 сая төгрөгийг, 2024 онд 2,033.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг

төлөвлөж 2,276.5 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, хуульд заасан чиглэлд зарцуулах орлогоос давсан хэсгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд нийт 67 торгууль ногдуулах эрх албан тушаалт байгаагаас Баянхонгор аймагт 36 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна.

2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 22 байгууллагын 31 эрх бүхий албан тушаалтан торгууль ногдуулах чиг үүргийг хэрэгжүүлсэн ба тайланд хугацаанд нийт 1,702.9 сая төгрөгийн 33,860 торгууль ногдуулсан байна. Үүнээс 1,530.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж (96.1 хувь), 5 байгууллагын 172.5 сая төгрөгийн торгуулийн орлого бүрэн хэрэгжээгүй байна.

2024 оны байдлаар нийт 1,205.8 сая төгрөгийн 29,420 торгууль ногдуулснаас 910.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж (92.1 хувь), 7 байгууллагын 467.5 сая төгрөгийн торгуулийн орлого бүрэн хэрэгжээгүй байна.

Нийт төлөгдсөн 77.9 сая төгрөгийн торгуулийн дүн нь 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу “торгуулиа заасан хугацаанд буюу 15 хоногт багтаан төлсөн тохиолдолд” торгуулийн дүнгээс 50%-иар хөнгөлөгдсөн хэсэг юм.

Харин 8.8 сая төгрөгийн 17 торгуулийг зөвхөн тухайн чиг үүргийн улсын ахлах байцаагч эсвэл тусгай мэргэжилтэн ногдуулах ёстой зөрчлийг энгийн байцаагч шийдвэрлэсэн, мөн зөрчил гаргасан тухай нотлох баримт дутуу, үндэслэл хангалтгүй, бусад шалтгаанаар шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын улсын байцаагчийн тавьсан 12.7 сая төгрөгийн торгууль шүүхийн шийдвэрээр хүчингүй болгох шийдвэр гарах явцад торгуулсан аж ахуйн нэгж байгууллага төлсөн тохиолдол гарсан.

Хүснэгт 4. Торгуулийн орлогын нэгтгэл /сая төгрөг/

Д/д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Эрх бүхий албан тушаалтны тоо	2023 он				Биелэлт	2024 он				Биелэлт
			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс		
					Төвлөрсөн	Дутуу	Хувь			Төвлөрсөн	Дутуу	Хувь
1	Баянхонгор Нийгмийн даатгалын газар	3	0.45	2	0.45	-	100.00	0.77	4	0.77	-	100.00
2	Архивын ерөнхий газар	1	0.40	4	0.40	-	100.00	0	0	-	-	-
3	Баянхонгор аймгийн Байгаль орчны газар	3	51.43	200	51.43	-	100.00	79.20	222	79.20	-	100.00
4	Баянхонгор Авто тээврийн төв	1	1.80	18	1.80	-	100.00	3.30	30	3.30	-	100.00
5	Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч	1	16.80	14	12.15	4.65	72.32	28.70	9	28.70	-	100.00
6	Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч	1	-		-	-	-	3.20	8	3.20	-	100.00
7	Авто замын хяналтын улсын байцаагч	1	-		-	-	-	0.30	1	0.30	-	100.00
8	Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар	2	49.20	75	49.20	-	100.00	26.50	36	26.50	-	100.00
9	Хэмжил зүйн улсын байцаагч	1	-		-	-	-	1.00	1	1.00	-	100.00

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

10	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	1	2.70	3	2.70	-	100.00	3.66	1	3.66	-	100.00
11	Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч	1	15.00	6	15.00	-	100.00	1.21	9	1.21	-	100.00
12	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар		715.10	32714	585.62	129.47	81.89	623.80	28234	387.61	236.19	62.14
13	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	2	254.81	78	242.31	12.50	95.10	68.54	60	54.60	13.94	79.66
14	Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	2	1.50	1	1.50	-	100.00	4.50	4	4.50	-	100.00
15	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	2	2.10	5	2.10	-	100.00	2.20	7	2.00	0.20	90.91
16	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	2	9.40	25	9.40	-	100.00	3.40	10	2.20	1.20	64.71
17	Эм, био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч	1	1.00	1	1.00	-	100.00	-	-	-	-	-
18	Баянхонгор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		272.34	168	272.34	-	-	163.33	120	163.33	-	100.00
19	Мал эмнэлгийн газар	1	-		-	-	-	5.00	1	5.00	-	100.00
20	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	3	46.70	59	43.60	3.10	93.36	28.20	68	19.40	8.80	68.79
21	Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	1	8.82	441	8.82	-	100.00	11.02	551	11.02	-	100.00
22	Баянхонгор аймгийн Татварын газар	1	253.32	46	230.52	22.80	91.00	147.94	44	113.30	34.64	76.59
	Нийт	31	1,702.87	33,860	1,530.35	172.52	96.10	1,205.77	29,42	910.79	294.97	92.14

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хүү, торгуулийн судалгаа

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Цагдаагийн газар 2023 онд 6,260 зөрчлийн торгуулийн орлогыг 129.5 сая төгрөгөөр, 2024 онд 14,127 зөрчлийн торгуулийн орлогыг 158.3 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй байна.
- Баянхонгор аймгийн Татварын газар 2023 онд 5 зөрчлийн торгуулийн орлогыг 22.8 сая төгрөгөөр, 2024 онд 10 зөрчлийн торгуулийн орлогыг 34.6 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй байна.

Иймд дээрх байгууллагад ногдуулсан 345.2 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлэх талаарх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан уу?

Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ногдуулсан байна.

Аудитад хамрагдсан эрх бүхий 22 байгууллагын нийт 31 албан тушаалтан торгууль ногдуулсан бөгөөд эдгээр албан тушаалтнуудын эрх зүйн үндэслэл, эрх бүхий этгээд эсэхийг түүвэрлэн шалгав.

Нийт 18 улсын байцаагчийн үнэмлэх, томилгооны тушаал болон бусад холбогдох баримт бичгийг бүрдүүлэн авч үзэхэд эрх олгосон баримт бичиг хүчин төгөлдөр болох нь нотлогдож байна.

Б.1.3. Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан уу?

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,781.8 сая төгрөгийн төлөвлөгөө баталж гүйцэтгэлээр 1,838.3 сая, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,946.0 сая төгрөгийн төлөвлөгөө баталж гүйцэтгэлээр 2,256.7 сая төгрөгийн орлого тайлагнасан байна.

Хүснэгт №5 Хүү торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл **сая төгрөг**

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Баянбулаг	3.0	5.9	2.9	197.7	3.0	6.5	3.5	217.3
Баянговь	5.0	3.6	- 1.4	71.3	5.0	3.7	- 1.3	74.9
Богд	5.0	3.3	- 1.7	66.3	4.0	8.7	4.7	218.6
Баянлиг	5.0	3.4	- 1.6	67.2	5.0	5.2	0.2	103.7
Баян-Овоо	20.0	28.5	8.5	142.3	20.0	22.0	2.0	110.2
Бөмбөгөр	40.0	89.8	49.8	224.6	60.0	92.0	32.0	153.3
Бууцагаан	30.0	83.7	53.7	278.9	45.0	138.3	93.3	307.3
Баянхонгор	138.8	177.6	38.8	127.9	250.0	200.2	- 49.8	80.1
Баацагаан	10.0	10.0	- 0.0	99.8	14.0	9.1	- 4.9	64.7
Баянцагаан	6.0	5.7	- 0.3	95.8	5.0	6.2	1.2	125.0
Баян-Өндөр	8.0	21.8	13.8	272.9	6.0	6.1	0.1	101.8
Галуут	20.0	16.8	- 3.2	84.2	28.0	27.9	- 0.1	99.8
Гурванбулаг	6.0	10.7	4.7	178.4	7.5	18.6	11.1	247.4
Жаргалант	10.0	15.8	5.8	158.4	10.0	7.9	- 2.1	78.8
Жинст	4.0	2.9	- 1.1	73.2	3.0	4.7	1.7	155.4
Заг	7.0	6.3	- 0.7	90.3	5.0	3.2	- 1.8	64.2
Хүрээмарал	13.0	17.9	4.9	137.8	4.0	2.6	- 1.4	64.1
Шинэжинст	8.0	21.4	13.4	267.1	15.0	13.8	- 1.2	92.2
Эрдэнэцогт	3.0	11.6	8.6	385.8	4.0	8.1	4.1	201.7
Өлзийт	70.0	163.0	93.0	232.8	170.0	229.1	59.1	134.8
Баянхонгор аймаг	1,370.0	1,138.6	- 231.4	83.1	1,282.5	1,442.7	160.2	112.5
Нийт	1,781.85	1,838.33	56.5	103.2	1,946.0	2,256.7	310.7	116.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх төсвийн гүйцэтгэлээр тайлагнасан дүнг татварын орлогын гүйцэтгэл мэдээтэй тулган шалгахад зөрүүгүй тохирч байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна уу?

Баянхонгор аймгийн татварын нийт орлого 2024 оны гүйцэтгэлээс үзэхэд хөнгөлөлт ороогүй дүнгээр 33,568.3 сая төгрөг байгаа бөгөөд хүү, торгуулийн орлого нийт татварын орлогын 5.7 хувийг эзэлж байна.

Дээрх дүнгээс 20 сумын татварын орлогыг харьцуулж үзэхэд дунджаар 3.3 хувийг хүү торгуулийн орлого эзэлж байгаа бөгөөд хамгийн их нь Өлзийт сум 23.2 хувь, хамгийн бага нь Хүрээмарал сум 0.3 хувийг эзэлж байна.

Харин аймгийн ерөнхий орлогын хувьд нийт орлого 3,587.5 сая төгрөгийн нийт татварын орлогоос 1,442.7 сая төгрөгийн хүү торгуулийн орлого буюу 40.2 хувийг эзэлж байгаагаас харахад татварын орлогод голлох нөлөө үзүүлж байна.

Б.2. Хүү, торгуулиас бүрдсэн орлогыг хууль, журмын дагуу хуваарилсан уу?


Б.2. Хүү торгуулийн орлогыг хуваарилахдаа орлогын биелэлтээс үл хамааран батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байна.

Б.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлсэн үү?

Аймгийн Засаг даргын тамгын газар хүү торгуулийн орлогын төлөвлөсөн хэмжээнд тулгуурлан хуульд заасан хэмжээгээр төсвийн төслийг тооцож, аймгийн ИТХ-д төсвийг өргөн барьж батлуулж байна.

Дараах графикаар ИТХ-аар баталсан 2023, 2024 оны Авто замын сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийн хуваарийг харууллаа.

Зураглал №3 Авто замын сан болон, ГХУС зардлын төсвийн хуваарь
/сая.төгрөг/



Санхүү, төрийн сангийн хэлтэс нь өөрийн эрхийн хүрээнд торгуулийн орлогын 40 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 12 сард тэгш хуваарилж, авто замын санд улирлын чанартай 4, 5 болон 6 саруудад өндөр дүнтэй, бусад саруудад жигд хуваарилсан байна.

Б.2.2. Хуваарилалтыг хийж буй аргачлал, тооцоолол баталсан шийдвэр хуульд тогтоомжид нийцсэн үү?

Хүү, торгуулийн орлогыг анх батлахдаа тухайн орлогын дүнд үндэслэн хуульд заасан хувь хэмжээгээр Авто замын сан болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцож баталдаг бөгөөд санхүүжилтийг олгохдоо орлогын гүйцэтгэлээс үл хамааран батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгож байна.

Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁹, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4¹⁰-д дэх заалт хангагдахгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.

⁹ торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

¹⁰ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

Иймд сар бүрийн санхүүжилт хуваарилалтыг хийхдээ эрх бүхий байгууллагаас торгуулийн мэдээг гаргуулан авч хүү торгуулийн орлоготой уялдуулан санхүүжилтийг хуваарилж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Б.2.3. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу хуваарилсан уу?

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хүрээнд төлөвлөж байгаа хүү торгуулийн орлогыг хуулийн дагуу авто замын сан болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд хэрхэн хуваарилсан талаар авч үзэв.

Авто замын хураамж болон торгуулийн орлогыг авто замын санд сар бүр гүйцэтгэлээр нь хааж оны эцэст давсан орлого замын сангийн үлдэгдлээр үлдэж байна.

Замын сангийн харилцах дансанд 2023 оны эхэнд 33.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 678.6 сая, авто зам ашиглалтын хураамж 335.0 сая, торгуулийн орлого 432.5 сая нийт 1,446.1 сая төгрөгийн санхүүжилт авч 19 төсөл арга хэмжээнд 1,440.9 сая төгрөгийн зардал гаргаж 39.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Замын сангийн харилцах дансанд 2024 оны эхэнд 39.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 727.3 сая, авто зам ашиглалтын хураамж 359.8 сая, торгуулийн орлого 396.7 сая нийт 1,483.8 сая төгрөгийн санхүүжилт авч 15 төсөл арга хэмжээнд 885.1 сая төгрөгийн зардал гаргаж 637.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Харин Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу торгуулийн орлогын 40 хувийг санхүүжилттэй нь уялдсан эсэхэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналтыг тавихгүй байна.

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзэж байна уу?

Торгууль ногдуулсан эрх бүхий байгууллагууд улсын байцаагчийнхаа гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэхдээ торгууль ногдуулсан эрх бүхий албан хаагчдын торгуулийн орлогын хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж байна. Тухайлбал:

Цагдаагийн газар: 3.11 Иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэл, шаардлага, зөвлөмж хүргүүлж, хариуг авч хэрэгжилтийг хангасан байх.

Санхүүгийн хяналт дотоод аудитын алба: Өнгөрсөн болон тайлант онд улсын байцаагчийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, өр төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах

Дээрх хоёр байгууллагын үнэлсэн байдлаас үзэхэд шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлсэн байдлаар нь албан хаагчдыг гүйцэтгэлийн тайланд биелэлтийг авч үзсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн Татварын газар, Байгаль орчны газар, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд нь торгууль ногдуулах эрх бүхий улсын байцаагчдын гаргасан торгуулийн шийдвэрийн хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогын хэмжээг алба хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлтэд тусгаж, ажил дүгнэхэд харгалзан үздэггүй байна.

Иймд дээрх байгууллагуудад торгууль ногдуулах эрх бүхий албан хаагчдын орлогын төлөвлөгөөний биелэлт, төвлөрүүлсэн орлогын хэмжээг ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд тусган, ажил дүгнэхэд харгалзан үздэг байх зохицуулалтыг нэвтрүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна

БҮЛЭГ В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ ?
АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨӨС ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН ГАРСАН БАЙНА.

В.1 Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

В.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зарцуулахдаа хуулийн дагуу зарцуулсан байна.

В.1.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан уу?

 **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал**

Баянхонгор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл (ГХУСАЗСЗ) нь 2023 онд нийт 238.9 сая төгрөгийн санхүүжилтээр 4 бүлэгт хамаарах 70 арга хэмжээг хэрэгжүүлж, 90.3%-ийн гүйцэтгэлтэйгээр төсвөө бүрэн зарцуулсан байна. 2024 онд 560.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 бүлэг, 82 арга хэмжээг төлөвлөж, 544.6 сая төгрөгийг зарцуулан 15.3 сая төгрөгийг төвлөрүүлснээр 97.1%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Хүү, торгуулийн орлогоос санхүүжүүлсэн төсөв нь тухайн жилүүдэд зориулалтын дагуу, төлөвлөгөөтэй уялдан зарцуулагдаж, хэрэгжилтийн түвшинг дүгнэхэд үр ашигтай байдал сайн байсан боловч зарим тохиолдолд төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 24-р захирамжаар хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг эргэхэд 3.4 сая төгрөг.
- Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 08-р захирамжаар Цагдаагийн газрын алба хаагч нарыг нөхөн сэргээх сувилалд амруулахад 4.0 сая төгрөг
- Крикетиин тэмцээний замын зардалд 2.8 сая төгрөг нийт 10.3 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5¹¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8¹² дах заалтыг зөрчсөн ба Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.5¹³ дах заалтад тусгагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн байна.

¹¹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹² байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах

¹³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна

Иймд төвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан 10.3 сая төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Түүнчлэн аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 13, 2024 оны 23 захирамжийн дагуу ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөний хүрээнд хоол, цайны зардал, сургалтын заалны түрээсэнд нийт 50.6 сая төгрөгийг зарцуулсан нь эрх зүйн хувьд зөрчилтэй гэж үзэх үндэслэлгүй боловч төсвийн хэмнэлтийн зарчим, төсвийн үр ашиг, зохистой байдал талаас авч үзвэл өндөр дүнтэй зардал гарсан байна.

Иймд Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг баримтлан үр ашиггүй зардал гаргахгүй байх зөвлөмжийг Аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Авто замын сан

Авто замын сангийн хөрөнгийг 2023–2024 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгохдоо гүйцэтгэлийн явц, холбогдох баримтад үндэслэн олгосон нь зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр:

- 2023 онд өмнөх оноос шилжих 1 төсөл, арга хэмжээнд 105.0 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 22 төсөл, арга хэмжээнд 1,543.9 сая төгрөг.
- 2024 онд нийт өртөг нь 2,973.7 сая төгрөг бүхий, 1,718.7 сая төгрөгийн санхүүжилттэй 16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн 2023, 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитаар Замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг хамруулан шалгасан.

Тухайлбал, 2024 онд Авто замын сангийн хөрөнгөөр 902.1 сая төгрөгийн өртөг бүхий 14 ажилд гэрээ байгуулж, 848.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитаар төслийн гүйцэтгэлийг талбайн үзлэг, холбогдох акт, санхүүжилтийн баримттай тулган шалгахад, ажлуудын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгосон нь баримтаар нотлогдсон.

В.1.2. Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулсан уу?

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 12/55 тогтоолоор 238.9 сая төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 тогтоолоор 560.0 сая төгрөг батлагдаж, тус хөрөнгийг хөтөлбөр 70105, арга хэмжээ 82201, зардлын эдийн засгийн 21090102-т хамруулан төрийн сангийн 100030050001 тоот дансаар

дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дах заалтын дагуу 2023 онд зөвлөлийн нарийн бичгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 25.0 сая төгрөг, 2024 онд нарийн бичиг болон аймгийн хэмжээнд нийт 28 олон нийтийн цагдаагийн урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлд 333.0 сая төгрөг холбогдох эдийн засгийн ангиллаар бүртгэж зарцуулсан бол гадаад албан томилолтын зардлыг эдийн засгийн ангиллын 210701-ээр төлөвлөж тайлагнаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 08,13 -р захирамжуудаар Тайвань улсад туршлага судлахад 10.2 сая төгрөгийн зардлыг 21090102 буюу бараа ажил үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

Иймд ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг эдийн засгийн ангиллыг нь зөв тусгаж гадаад албан томилолтын зардалд төлөвлөж, тайлагнаж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн ИТХ-д өгөв.

Замын сангийн хөрөнгийн санхүүжилтийг эдийн засгийн ангилал хооронд зохицуулалт хийгээгүй, зориулалт бусаар зарцуулаагүй байна.

В.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байна уу?

2023 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд 3, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд 51, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд 5, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээнд 9, нийт 27 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 22.598 иргэн сургалтад хамрагдаж 22.675 ширхэг гарын авлага, санамж, зөвлөмж тарааж ажилласан байна.

2024 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд 5, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд 55, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд 1, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ, дэмжлэг үзүүлэх чиглэлийн хүрээнд 3, нэмэлтээр 18 нийт 25 сургалтаар давхардсан тоогоор 44.606 иргэн сургалтад хамрагдаж 37.500 ширхэг гарын авлага, санамж, зөвлөмж тарааж 2 жилийн хугацаанд салбар зөвлөлийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 67.204 иргэнд хүргэж холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан байна. Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо, хамтран ажилласан байгууллагын тоо зэргээс үзэхэд хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд хүртээмжтэй байж, нийгмийн тодорхой

хэсгийг хамарсан, уялдаа холбоотой зохион байгуулалттай байсан нь харагдаж байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд авто замын арчлалт хамгаалалт, явган хүний зам шинээр тавих, замын тэмдэг тэмдэглэгээ сайжирч, нийтийн эзэмшлийн зам талбай нэмэгдсэнээр олон нийт үр ашгийг нь хүртэж байна.

В.1.4. Нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлж байна уу?

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2024 онд Цагдаагийн газрын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн системийг сайжруулахад 39.7 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр хангаж 6 хэсгийн байцаагч байгууллагын нэгдсэн мэдээллийн санд холбогдож нэвтрэх хурд 4-5 дахин нэмэгдэж, мэдээллийн аюулгүй байдал хангагдсан. Мөн Шүүхийн шинжилгээний хэлтэст 3.8 сая төгрөгийн 348 ширхэг сангийн баяжилт хийсэн гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан байна.

Тайлант хугацаанд Баянхонгор аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал дараах байдлаар өөрчлөгджээ:

- 2023 онд гэмт хэргийн тоог 2022 онтой харьцуулахад 44 нэгжээр буюу 10 хувиар буурсан байна.
- 2024 онд 516 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 337 буюу 73.7 хувь нь Баянхонгор суманд, 179 буюу 11.2 хувь нь бусад суманд үйлдэгдсэн.
- 2024 онд гэмт хэргийн тоог 2023 онтой харьцуулахад 161 нэгжээр буюу 45.4 хувиар өссөн.

Зөрчил: 2024 онд нийт 29.930 зөрчил шалгасан нь 2023 онтой харьцуулахад 3.679 нэгжээр буюу 10.9 хувиар буурсан. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 2024 онд 56.3% байгаа нь 2023 онтой харьцуулахад 10.4 нэгжээр өссөн.

- Гэмт хэргийн улмаас 482 иргэн, байгууллага хохирч, үүнээс 173 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18 нэгжээр буюу 11.6 хувиар өсөж, 8 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 5 нэгжээр буюу 38.5 хувиар буурсан байна.
- Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага аж ахуйн нэгжид 2132.6 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 617.8 сая төгрөг буюу 22.5 хувиар буурсан. Харин 584.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 171.1 сая төгрөг буюу 41.4 хувиар өссөн.
- Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх сургалтын хүрээнд 21.1 сая төгрөг зарцуулж Тайлант онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 17 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Цахим хуудасны ил тод байдал 100 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 6.7 хувиар өссөн байна.
- Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд 23.9 сая төгрөг зарцуулж, согтуугаар үйлдэгдсэн зөрчил 1.268 бүртгэгдэж 30.5 хувиар буурсан байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд 23.1 сая төгрөгийг зарцуулж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 25 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буурсан. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 244 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд 26.2 сая төгрөгийг зарцуулж Юнител компанийн сүлжээ бүхий 5 сумын 7.500 малчин иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий зөвлөмжийг хүргэсэн, бод малын байршил тогтоогч "GPS tracker" төхөөрөмж 120 ширхгийг малын хулгайн гэмт хэрэг их үйлдэгддэг 12 сумдад хуваарилан суулгасан нь мал хулгайлах гэмт хэрэг 18 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 нэгжээр буюу 35.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна уу?

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг Шилэн данс, олон нийтэд мэдээллийн сувгаар хүргэж ил тод мэдээлсэн байна.

В.2.1.Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансанд бүртгэсэн үү?

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих Баянхонгор аймгийн ИТХ-аас баталсан төсөв, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилт, иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжуудыг 2023 онд Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 -д заасан орлогын 238.9 сая төгрөгийн 9 мэдээлэл, зарлагын 54.9 сая төгрөгийн 7 мэдээлэл, Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 -д заасан 202.6 сая төгрөгийн 75 шийдвэр, 2024 онд Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 -д заасан орлогын 560.0 сая төгрөгийн 13 мэдээлэл, зарлагын 84.0 сая төгрөгийн 9 мэдээлэл, Шилэн дансны тухай хуулийн 6.4.8 "Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл" заасан 196.7 сая төгрөгийн 70 шийдвэрийг мэдээлсэн байна.

В.2.2. Эрх бүхий байгууллага нь хүү, торгуулийн орлогын зарцуулалтын тайлан, мэдээллийг олон нийтэд мэдээлсэн үү?

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа, замын сангийн зарцуулалтын тайлан, мэдээллийг олон нийтэд дараах сувгаар хүргэсэн байна. Үүнд: Орон нутгийн телевизийн суваг Баянхонгор телевиз, Хонгор телевиз өдөрт 3-4 удаагийн давтамжаар, Монголчуудын MGL радио 88.3 сувгаар долоо хоног бүрийн мягмар пүрэв гаргуудад өдрийн 2 удаагийн давтамжтай нийт 88 удаа тус радиогоор, гудамж талбайн лед дэлгэцээр 836 удаа, фейсбүүк хуудсаар 35 удаагийн давтамжаар, аймгийн нэгдсэн вэб хуудас <https://bayanhongor.gov.mn> болон "Нээлттэй засаг - Нэг Баянхонгор" фейсбүүк хуудсаар 5.200 иргэний хандалт авч мэдээллийг хүргэсэн байна.

В.2.3. Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлсэн үү?

Төрийн аудитын байгууллагаас аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд жил бүр хийдэг санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээс бусад тохиолдолд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас албан ёсны үнэлгээ, санал, дүгнэлт ирүүлээгүй байна.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙГААГААС ОРЛОГО ТӨВЛӨРӨЛ ДУТУУ, ЗАРЦУУЛАЛТАД АЛДАА ГАРЧ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД БОДИТООР НЭГТГЭН ХЯНАХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

Г.1 Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байна уу?

Г.1. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс шалтгаалан Монгол Улсын хэмжээнд нэг өдөрт хэдий хэмжээний торгууль ногдуулж, хэрэгжилт нь ямар түвшинд байгааг бодитой, нэгтгэсэн байдлаар хянах боломжгүй байна.

Г.1.1. Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан бий болсон уу?

Өнөөдрийн байдлаар байгууллага тус бүрдээ хүү, торгуулийн орлогын бүртгэлийн сан (программ) хангамжтай боловч байгууллага хооронд мэдээлэл солилцох нэгдсэн сан байхгүй нь тухайн эрх бүхий байгууллагын тогтоосон торгуулийн орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэнд орсон үед нь мэдэж байна. Энэ нь торгуулийг тухайн тогтоосон цаг хугацаанд төлөгдөж байгаа дээр хяналтгүй орлого тасрах магадлал өндөр байна.

Цаашид эрх бүхий байгууллагууд мэдээлэл солилцох нэгдсэн сантай болох шаардлагатай байна.

Монгол улсын хэмжээнд 1 өдөрт хэдэн торгууль ногдуулж байгаа тоо мэдээг нэгтгэсэн нэгдсэн систем өнөөдрийн байдлаар байхгүй байна.

Иймд Хүү торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг орчин үеийн технологитой нийцүүлэн боловсруулах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлав.

Г.1.2. Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт хангагдаж чадаж байна уу?

Торгуулийн төлбөрийн системийг торгуул оногдуулах эрх бүхий байгууллагуудаас цагдаагийн байгууллага бүрэн ашиглаж байна.

Замын цагдаа нь “E-Paltol” аппликейшн-ыг ашиглан торгууль ноогдуулж байгаа нь тухайн орон нутгийн төрийн сангийн данстай шууд холбогдсон тул төлсөн торгууль нь тухай бүртээ төрийн сангийн дансанд орлогоор бүртгэгдэж байна. Харин торгуулийн төлбөрийг цахим орчинд дараах аппликейшнг ашиглан төлөх боломжтой. Үүнд: Smartcar.mn, E-Mongolia систем, Төрийн банкны “Гялс банк” Голомт банкны “Смарт банк”, “SocialPay”, татварын “ebarimt.mn

Бусад торгууль ноогдуулдаг эрх байгууллагуудын хувьд төрийн сангийн дансны хуулга авч тулган баталгаажуулалт хийсэн дараа л торгууль төлөгдсөн эсэхийг мэдэж байна нь торгууль барагдуулах, хянах, мэдээлэхэд хүндрэл учруулж байна.

Г.1.3. Хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна уу?

Аудитын явцад хийсэн шалгалтаар торгуулийн орлогын бүрдүүлэлтэд төвлөрсөн, системтэй хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, бие даасан хяналтын систем үйл ажиллагаа байхгүй торгууль тогтоосон эрх бүхий албан тушаалтан нь л тухай торгуулийг барагдуулдаг нь орлогын бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Мөн торгуулийн орлогын төлөвлөгөө биелэхгүй үед аймгийн Засаг даргын захирамжаар замын цагдаа, татварын байцаагч нараас бүрдсэн ажлын хэсэг байгуулан замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл шалгах үйл ажиллагаа зохион байгуулдаг ч тухайн зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх эрх зүйн үндэс дутмаг байгаа тул үр дүн муутай, тогтвортой шийдэл болж чадахгүй байна.

Иймд тулд торгуулийн орлого бүрдүүлэлтийг хянах төвлөрсөн, ил тод, бие даасан хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна. /Г.1.1 зөвлөмжийн агуулгыг тусгасан/

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн үү?

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий албан тушаалтнууд болон, улсын байцаагчид хяналтыг хэрэгжүүлсэн боловч орлого төвлөрүүлэлт дутуу, зарцуулалтад гарсан алдаа зөрчлөөс харахад хяналтын үр нөлөө сул байна.

Г.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан уу?

Аудитын хамрагдсан 2023, 2024 онуудад нийт 2,908.1 сая төгрөгийн торгууль ногдуулсан бөгөөд үүнээс 2,441.1 сая төгрөгийн орлого бүрэн төвлөрсөн байна. Харин үлдэгдэл 467.0 сая төгрөгийн торгуулийн дүнгээс:

- 77.9 сая төгрөг нь хуулийн хүрээнд 50%-иар хөнгөлөгдсөн.
- 8.8 сая төгрөг нь зөвхөн тухайн чиг үүргийн улсын ахлах байцаагч, эсвэл тусгай мэргэжилтэн ногдуулах эрх бүхий зөрчил байсан боловч энгийн байцаагчийн шийдвэрээр ногдуулсан тул эрх зүйн үндэслэлгүйд тооцож хүчингүй болгож үлдэгдэл 380.8 сая төгрөгийн орлого төсөвт дутуу төвлөрсөн байна.

Торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй шалтгааныг судлан, нөхөн барагдуулах болон шаардлагатай арга хэмжээг авах талаар дараагийн шатны зохион байгуулалт, хяналтын ажиллагаа хангалтгүй байсан нь орлого дутуу төвлөрөхөд нөлөөлсөн байна.

Тухайлбал:

Цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийг биелүүлэх нэгдсэн арга хэмжээг авч байгаа ч иргэдийн шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн идэвхгүй ашиглалт, мэдэгдэл хүрдэггүй байдал, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа, хамтын ажиллагааны сул тал зэргээс шалтгаалан бэлэн бусаар ногдуулсан торгууль бүрэн барагдахгүй байна.

Татварын байгууллагын хувьд хяналт шалгалт хэрэгжүүлэх болон орлого төвлөрүүлэх чиг үүрэг нь өөр өөр албан тушаалтнуудад хуваарилагдан ажиллаж

байгаа нь тогтоосон торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд хүндрэл учруулж байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй зээл, зээлийн хүүгийн авлагыг жил бүрийн Санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгч барагдуулж, байгаа бөгөөд биелэгдээгүй авлагыг сумдын ХХС Шүүхээр шийдвэрлүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

Иймд Хүү торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг орчин үеийн технологитой нийцүүлэн боловсруулах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлав

Шүүхийн шийдвэр гарч ШШГ-т шилжүүлсэн зээл хүүгийн үлдэгдэл 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар зээл, хүүгийн авлага 123.6 сая төгрөг байсан бол 2024 онд 198.2 сая төгрөг болж өссөн байна.

Энэ нь өмнөх оноос зээл, хүүгийн авлаа нь төлөгдсөн 109.1 сая төгрөг, нэмэгдсэн 183.9 сая төгрөг болж 74,5 сая төгрөгөөр өссөн байна. ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагаас хүүгийн орлогыг тусад нь салгаж тооцох боломжгүй байна.

Г.2.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна уу? Хяналт нь үр дүнтэй байна уу?

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газар нь аймгийн Цагдаагийн газрын 2023, 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ замын цагдаагийн цахимаар торгосон байдал, торгуулийн орлогын төлөлт дээр хяналт хийдэггүй бөгөөд үндсэн үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга аймгийн Татварын хэлтэс, Цагдаагийн газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт дотоод аудитын газар, улсын байцаагч нарт татварын болон хүү, торгуулийн орлого төвлөрүүлэлтийн ажлыг жил бүр зохион байгуулж эрчимжүүлэх талаар 2023, 2024 онуудад нийт 7 удаагийн захирамж гарган хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Баянхонгор аймгийн засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн “Хүү, торгуулийн орлогыг барагдуулах” тухай А/115 дугаар захирамжаар аймгийн цагдаагийн газар, татварын хэлтэс, улсын байцаагч нарт чиглэл өгч орлого төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласан бол 2024 онд хүү торгуулийн орлого төвлөрүүлэх талаар тусгайлан захирамж шийдвэр гаргаагүй байна.

Аймгийн татварын газарт 2023, 2024 онуудад хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд Татварын ерөнхий газраас тусгайлан хяналт шалгалт хийгээгүй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн болон Авто замын хяналтын улсын байцаагч нар хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг ГХУСАЗС зөвлөлийн нарийн дарга Ж.Наранбаатар нар хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд эрх бүхий байгууллагууд нь торгуулийн орлогын бүрдүүлэлт болон зарцуулалт дээр хяналт хэрэгжүүлж байгаа боловч уг хяналтын үр дүн сул байна.

Г.2.3. Орлого төвлөрүүлэгч байгууллагууд нь торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлсэн үү?

Тайлант хугацаанд торгуулийн орлого төвлөрүүлэх үүрэгтэй байгууллагууд нь зөрчлийн торгуулийн орлогод хангалттай дотоод хяналт хэрэгжүүлээгүй улмаас орон нутгийн төсөвт бүрэн төвлөрөөгүй байна. Тухайлбал:

Цагдаагийн газар 13.822 зөрчлийн 287.8 сая, Татварын газар 15 зөрчлийн 57.4 сая, нийт 13.837 зөрчлийн 345.2 сая төгрөгийн торгууль нь тухайн онд төсөвт дутуу төвлөрсөн байна.

Цагдаагийн газрын замын хөдөлгөөний торгууль нь төлбөрийн системтэй нь зөрчлийн хэрэг бүртгэгч нь тухайн торгуулийг рапортын дэвтэртэй нэг бүрчлэн тулган баталгаажуулалтыг гараар хийж рапортын дэвтэрт засвар орсон бол тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулдаг байна.

Бусад байгууллагад улсын байцаагчийн тогтоосон торгуулийн орлогыг хянах тогтолцоо байхгүй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5.1¹⁴-т заасны дагуу тухайн албан тушаалтан өөрөө хариуцан ажиллаж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогын хувьд бүрдүүлэлт зарцуулалтад Сумын ИТХ-аас ажлын хэсэг байгуулж хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Г.2.4. Хөндлөнгийн байгууллагуудаас /Иргэн, ТББ, ОУБ, Зөвлөл г.м/ хяналт хэрэгжүүлсэн үү?

Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлтэд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй ч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хүрээнд Төрийн аудитын байгууллага болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба жил бүр санхүүгийн тайлан, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

Мөн Хоршоо хөгжүүлэх сан болон Баянхонгор-Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллага жил бүр баталгаажуулах аудитыг хийж гүйцэтгэж байна.

Аудитаар нийт 416.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 20.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгч, орлого төвлөрүүлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 395.8 сая төгрөгийн 7 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

¹⁴ Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хүү, торгуулийн орлогыг урьдчилан үндэслэлтэйгээр тооцоолж, бодит байдалд нийцүүлэн төлөвлөх нөхцөл бүрдээгүй байна.
2. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.
3. Төлөвлөсөн торгуулийн орлого даван биелсэн ч эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.
4. Хүү торгуулийн орлогыг хуваарилахдаа орлогын биелэлтээс үл хамааран батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байна.
5. Авто замын сангийн хөрөнгөөр хийсэн төсөл, арга хэмжээ болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд зарцуулсан хөрөнгөөс тодорхой хэмжээний үр дүн гарсан байна.
6. Хүү, торгуулийн орлогын зарцуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг Шилэн данс, олон нийтэд мэдээллийн сувгаар хүргэж ил тод мэдээлсэн байна.
7. Монгол улсын хэмжээнд 1 өдөрт хэдэн торгууль ногдуулж байгаа тоо мэдээг нэгтгэсэн нэгдсэн систем өнөөдрийн байдлаар байхгүй байна.

-oOo-

ЗӨВЛӨМЖ:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байдалд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах.

ХОЁР. БАЯНХОНГОР ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА:

2. Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг баримтлан байрын түрээс зардлыг зогсоож, хоол цайны зардлыг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

3. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүүг жил бүр дүгнэж, давсан болон дутсан голлох шалтгаануудыг бодит үндэслэлтэйгээр үнэлэх, Төрийн байгууллагуудаас төвлөрөх хүү, торгуулийн орлогын тасалдах болон нэмэгдэх эрсдэлийг үнэлж байх тогтолцоог бүрдүүлэх.

4. Сар бүрийн санхүүжилт хуваарилалтыг хийхдээ эрх бүхий байгууллагаас торгуулийн мэдээг гаргуулан авч хүү торгуулийн орлоготой уялдуулан санхүүжилтийг хуваарилж байх.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАЯР ТАНАА

5. Алба хаагч нарын ногдуулсан 287.8 сая төгрөгийн торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байдалд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах.

ТАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА С.РЭНЦЭНДАГВА ТАНАА:

6. Татварын улсын байцаагчийн ногдуулсан 57.4 сая төгрөгийн торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байдалд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах.

ТАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАР, ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, БАЙГАЛЬ ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА НАРТ:

7. Ажил дүгнэхдээ торгууль ногдуулах эрх бүхий албан хаагчдын шийдвэрийн хэрэгжилтийг ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд тусган Төрийн албаны тухай хуулийн 37.1.13 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн дараа жилийн хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллагад зөвлөмжөөр хүргүүлэх.
2. Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх “жолооны үнэмлэхийн хугацаа дууссан” энэхүү заалтыг орчин үеийн техник технологитой уялдуулан цахим бүртгэлээр зөрчил гаргаагүй жолоочид автоматаар үнэ төлбөргүй сунгах эрх зүйн зохицуулалт оруулах зөвлөмжийг эрх бүхий байгууллагад хүргэх.
3. Хүү торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг орчин үеийн технологитой нийцүүлэн цахимжуулах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх.
4. Иргэд төрийн цахим үйлчилгээ авах үедээ өөрийн нэр дээр оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг мэдэгдлээр авах, торгуулийн төлбөр төлөгдөөгүй тохиолдолд зарим цахим үйлчилгээг түр хугацаагаар хязгаарлах, төлбөрийг барагдуулсны дараа үйлчилгээг сэргээх зохицуулалтыг журамд тусгах талаар эрх бүхий байгууллагад зөвлөмжөөр хүргүүлэх.

-oOo-